

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№23/581

ШУС, НУС

2022

**МОНЦАМЭ-ИЙН ТҮҮХЭНД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛСАН СЭТГҮҮЛЧДИЙН
БҮТЭЭЛИЙГ ҮНЭЛЭН ЦЭГНЭХҮЙ**

М.Наранчимэг*

*Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: Мэдээллийн агентлаг, сэтгүүлч, мэдээлэх үүрэг, улс төр, эдийн засгийн тойм.

Түүхт энэ байгууллагын анхны мэдээ нь одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутгаас 1921 оны 3-р сарын 18-нд хувьсгалт цэргүүд Хиагтыг эзэлсэн тухай бөгөөд энэ мэдээний хамт Монгол Ардын түр засгийн газар Хиагтад байгуулагдсан талаарх мэдээг МОНТА нэрээр Оросын РОСТА агентлаг руу дамжуулжээ. Энэ үеэс эхлэн МОНЦАМЭ нь Монгол Улсыг дотоодод төдийгүй гадаадад сурталчлах үндсэн үүрэгтэйгээр ажилласаар эдүгээ 100 жилтэйгээ золгож байна. “МОНЦАМЭ” агентлагийн үйл ажиллагаа 1957 оноос хойш эрс эрчимжиж, Монгол Улсын гадаад сурталчилгааг түлхүү эрхлэн англи, орос, хятад, япон хэлээр цаасан болон цахим хэлбэрээр мэдээ, мэдээллийг түгээж иржээ. МОНЦАМЭ “Монгол улсын дуу хоолой” болж, өнгөрсөн 100 жилийн түүхээ бичсэн бөгөөд ойрын ирээдүйд ч хамгийн их эрэлт хэрэгцээ бүхий хэвлэл мэдээллийн байгууллага байсаар байх нь дамжиггүй.

Зуун жилийн түүхтэй тус байгууллагад ажиллаж байсан бүх сэтгүүлчийн бүтээлийг энд тоочвол багагүй цаг орно.

“Монгол Улсын дуу хоолой” шилмэл бүтээлд 150 гаруй сэтгүүлчийн бүтээлийг багтаасан байна. Ахмад, дунд, залуу үеийн төлөөллийн нийтлэлээс сонгон судалж, бичлэгийн агуулга, арга хэлбэр, ур чадварт дүн шинжилгээ хийхийг зорив.

“Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботийн 22 дахь дугаар нь Монголын Үндэсний Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн ойд зориулан “Монгол Улсын дуу хоолой” нэртэйгээр гарсан юм. Энэхүү 2 боть номын эхэнд агентлагийн дарга өмнөх үгийг бичиж, дараах хуудсанд (МОНЦАМЭ агентлагийн Ерөнхий захирлаар ажиллаж байсан сэтгүүлч, доктор, профессор Т.Баасансүрэнгийн санаачилгаар 2000 онд зохиогдож, батлагдсан сэтгүүлчдийн баримтлах “Алтан дүрэм”-ийг оруулсан байна.

Уг дүрэм нь МОНЦАМЭ агентлагийн хувьд төдийгүй Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудын түүхэнд анхдагч аж. “МОНТА-аас РОСТА”-д дамжуулсан “Монголчуудын бослого” нэртэй 1921 оны анхны мэдээгээ номын зургаа дахь хуудсандаа оруулжээ.

Шилмэл бүтээлийн түүврийн нийтлэлийн бүтцэд задлан шинжлэл хийхэд мэдээллийн бичлэгийн төрөл буюу мэдээ, тайлан, ярилцлага, сурвал-

жилга, тойм, сурвалжилсан тэмдэглэл нийт бичвэрийн 40 хувийг эзэлж байна. Тус бүтээлд 150 хүний 150 бичвэр багтжээ.

Өнгөрсөн 100 жилийн дотор МОНЦАМЭ агентлагийн эрхлэн хэвлүүлсэн ном, товхимол цөөнгүй бий. Ялангуяа сүүлийн 20 жилд буюу тус агентлагийн 80, 85, 90, 95 жилийн ойнуудаар нэг биш сонирхолтой ном бүтээлүүд хэвлэгдсэн байна. Тухайлбал, “Миний нэр, миний гэр-МОНЦАМЭ” ном, “Монголд мэдээллийн агентлаг үүсэн хөгжсөн нь”, “МОНЦАМЭ агентлаг 80 жилийнхээ ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн нь” ЭШХ-ын тэмдэглэлийг 2001 онд, МОНЦАМЭ агентлаг: “Үүсэл хөгжил, түүхэн замнал, ойрын ирээдүйн стратегийн зорилт” ЭШХ-ын илтгэлээр 2011 онд, “Хос морьтнууд” үе үеийн уран бүтээлчдийн нийтлэлээр 2006 онд, “Мэдээллийн агентлагийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлага” ЭШХ-ын эмхэтгэл, “МОНЦАМЭ-Дэлхийг Монголд, Монголыг дэлхийд” хэмээх номыг 2016 онд тус тус хэвлэн гаргасан байна.

Дээр дурдсан бүтээлүүдийг харьцуулан үзэж, “Монгол Улсын дуу хоолой” 2 боть номын нийтлэлүүдийг


нэгтгэн шинжилж, ажиглалт судалгааг баяжуулбал илүү сонирхолтой үнэлэлт дүгнэлт хийх, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулан судлах боломж бий гэж үзэж байна.

Энд зөвхөн “Монгол Улсын дуу хоолой” шилмэл бүтээлийг сонирхон судалж, уран бүтээлчдийн бичлэгийн агуулга, арга барилд дүн шинжилгээ хийсэн.

Бичлэгийн төрөл зүйлээр ангилбал: мэдээллийн бичлэгийн төрлөөр 60 нийтлэл бичсэний дотроос ярилцлага-22, сурвалжилга-8, сурвалжилсан тэмдэглэл-19, тойм-9, дэлгэрэнгүй мэдээ-1, тайлан-1 байна.

Шинжлэлт бичлэгийн төрлөөр асуудал дэвшүүлсэн болон хөндсөн өгүүлэл-36, төрөгдөл буюу эсээ-2, эрэн сурвалжилсан нийтлэл-2 байна.


Харин нийтлэл уран сайхны бичлэгийн төрлөөр хөрөг найруулал-9, шог найруулал-1, тэмдэглэл-38, үүнээс аян замын тэмдэглэл-19, үйл явдлын тэмдэглэл-2, бусад нь дурдатгал дурсамж тэмдэглэл эзэлж байгаа болно. Памфлет буюу егөөдөл, ёгтлол хэлбэрийн бичвэр -2 байна. Эдгээр төрөл зүйлийг тус бүрд нь диаграммаар ангилан харуулав.



Үүнээс ярилцлага 37 хувь, сурвалжилсан тэмдэглэл 32 хувийг, тойм 14 хувийг, сурвалжилга 13 хувийг

тус тус эзэлж байгаа бол тайлан, дэлгэрэнгүй мэдээ тус бүр нэг байна.


Мэдээллийн бичлэгийн төрөл



Шинжлэлт бичлэгийн төрөл болох өгүүллийн зүйл /асуудал дэвшүүлсэн болон хөндсөн/ нийтлэл 90

хувийг эзэлж байгаа бол эсээ, эрэн сурвалжилга тус бүр 5 хувийг эзэлжээ.

Шинжлэлт бичлэгийн төрөл



Нийтлэл уран сайхны бичлэгийн зүйл болох хөрөг найруулал 18 хувийг, шог найруулал 2 хувийг, тэмдэглэл 77 хувийг эзэлсэн байна. Арван есөн уран бүтээлч аян замын тэмдэглэл бичсэн

бол хоёр уран бүтээлч үйл явдлын тэмдэглэл, харин дурсамж тэмдэглэлийг арван долоон сэтгүүлч бичжээ. Памфлет буюу егөөдөл, ёгтлол хэлбэрийн бичвэр -2 байна.

Нийтэл, уран сайхны бичлэгийн төрөл



Тус номд орсон 150 уран бүтээлчийн нийтлэлийг бүгдийг нь задлан шинжил-

бэл багагүй цаг хугацаа, хэдэн арван хуудас бичилт хийх болох тул цөөн

сэтгүүлчдийн бүтээлийг сонгон авч шинжлэв.

Номын 7 дугаар хуудас 100 жилийн түүхтэй ууган хэвлэл мэдээллийн байгууллагад орчуулагч, хариуцлагатай редактораар ажиллаж байсан Д.Абмадын “Гүегийн тавилан” хэмээх бяцхан хөрөг нийтлэлээр эхэлж байгаа юм. Нийтлэлийн үндсэн агуулга хувьсгалаас өмнө нутгийн баян Дампилийнд зарцлагдаж амьдарч байсан Гүегийн хувь заяа хувьсгалын ачаар хэрхэн хувирч өөрчлөгдөж, хөдөлмөр бүтээлээрээ манлайлан, 1957 онд БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллага болох АИХ-ын депутатаар сонгогдсон тухай намтарчлан өгүүлжээ. Уг хөргийг 384 үгэнд багтааж, өргөн агуулгыг илэрхийлэн бичлэгийн хувьд хөрөг найрууллын хэлбэрээр бичсэн байна. Энэхүү нийтлэлийг 1961 онд туурвисан бөгөөд “Эдгээр намтрыг социализм бүтээжээ” хэмээн (Адъяа.Г, Тэр шөнө халхын уудам нутаг маань доргих шиг болж билээ, 2021) төгсгөжээ.

Үүгээр социалист нийгэм “харц ардад эрх чөлөөтэй амьдрах, хөдөлмөрлөх эрх тэгш боломж олгосон шүү” гэдгийг дөрөвхөн үгээр илэрхийлэн гаргаж тавьсан байна. Хөргийн онцлог шинж нь тухайн сонгож авсан баатрын оюун санаа, дотоод ертөнцийг нээж, түүний зан байдал, үйл хөдлөл нь нийгмийн тодорхой үйл явдал, үзэгдэл, зөрчилтэй байдал, үзэл санаа, үг яриа, гадаад байдлыг илрүүлэн гаргадаг онцлогтой билээ.

“Гүегийн тавилан” хэмээх хөрөг нийтлэлийг бичигч Гүегийн амьдралаар дамжуулан нийгмийн өөрчлөлтийн явцад түүний амьдралд тохиолдсон онцгой цаг мөчийг, бага насандаа туулж өнгөрүүлсэн хэцүү бэрх амьдрал, тэвчээр хатуужилтай нь холбох замаар

уран нийтлэлийн аргаар нээн харуулж чадсан байна.

Удаах нийтлэл нь Гэлэгийн Адъяагийн “Тэр шөнө халхын уудам нутаг маань доргих шиг болж билээ” хэмээх сурвалжилсан тэмдэглэлээр үргэлжилж байна.

Тэрбээр МОНЦАМЭ агентлагт утга зохиолын ажилтан, орчуулагч, хариуцлагатай редактор, орлогч даргаар ажиллаж байсан, төр нийгмийн зүтгэлтэн хүн юм. МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн даргаар сонгогдон ажиллаж байхдаа БНМАУ-ын иргэн сансрын нислэгт оролцохтой холбогдсон ажлын бэлтгэл, явцыг зохион байгуулах, сурталчлах асуудал эрхэлсэн комиссын даргаар ажиллаж байсан түүхэн үйл явдлын гэрч.

Монгол Улс сансрын уудамд иргэнээ илгээсэн 10 дахь орон болсон тухай энд мэдээлсэн байна. “Сансрын хөлөг нисэх мөч ойртсоор... В.Жанибеков, Ж.Гүррагчаа нар улсын Комиссын даргад нислэгт бэлэн байгаа тухайгаа рапортлож байхад манай төлөөлөгчид бараг дэргэд нь зогсож байлаа”. (Адъяа.Г, Тэр шөнө халхын уудам нутаг маань доргих шиг болж билээ, 2021).

Энэ мөчид би хэдэнтээ зураг дарж амжсан бөгөөд хожим үзвээс түүний нэг дээр нь олон тооны сэтгүүлчид, тэдгээрийн дотор Монголын фото сэтгүүлчид, телевиз, киноны зураглаачид харагдаж байв.

Нисэгчид хөлгийн бүхээгтээ байраа эзлээд нэлээд удах зуур манай төлөөлөгчид, Зөвлөлтийн албаны хүмүүс, мэргэжилтэн, сансрын нисэгчдийн хамтаар ажиглах байранд очиж хүлээсэн юм. Тэр оройн тэнгэр, агаар захиалсан юм шиг цэв цэлмэг, тогтуун сайхан байв. Хааш л харвал Байконурын нүд алдам уудам тал цэлэлзэх нь

эгээ л Монголын говь юм уу даа гэлтэй...

Радио, телевизээр “Союз-39” хөлгийн дарга В.Жанибеков нислэгтэй холбогдуулан мэдэгдэл хийв. Гарааны өмнөх тоололт эхлэв. Тоололт дуусч “Пуск!” (Асаагаад!) гэсэн команд цуурайтахад, нүд гялбан гэрэл цацарч, чих дөжрөм чимээ гарав. Хөлөг гарааны талбайгаас алгуурхан хөдөлснөө тэр дороо хурдаа авч, цагаан зам татуулан чанх өөдөө довтолгов” гэх мэтээр тухайн газрын орчин ахуй, тухайн цаг мөчийн талаар дүрслэн бичихийн зэрэгцээ, Б.Явуухулангийн шүлэглэлээр хүмүүний баяр бахдал, сэтгэл догдлолыг илэрхийлэн харуулжээ.

Үйл явдал, үзэгдэлд задлан шинжлэл хийж, үнэлэлт дүгнэлт өгөх нь энэ бичлэгийн зүйлийн үндсэн зорилт. Энэ бол Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн түүхэн дэх тод нэгэн бичвэр, түүхэн үйл явдлыг сурвалжилсан онцгой нэгэн тэмдэглэл мөн. Уг нийтлэлийг сурвалжилсан тэмдэглэл гэж үзэх үндэс нь бодит баримтыг мэдээлэхээс эхлээд тухайн үйл явдал болсон газрын орчин тойрныг дүрслэн зураглаж өгүүлсэн байдал, зохиогч өөрөө үйл явдалд оролцсоноор илэрч байна.

Тоймч Б.Алтанхуягийн “Иргэншсэн хотоос умардын нүүдэлчид хүртэл” аян замын тэмдэглэлийг онцлон нэрлэхийг хүсэж байна. Уг тэмдэглэл сонирхол татах олон арван баримт сэлтэд тулгуурлан, туулсан замынхаа адал явдлыг байгалийн араншинтай сүлэлдүүлэн, тоочин бичихийн зэрэгцээ тухайн газар орны байр байдлыг илэрхийлэхдээ уран дүрслэлтэй, зураглалтайгаар өгүүлэхийн хамт үгийн сонголтод ихэд анхаарсан нь тэмдэглэлийг уншихад аяндаа анзаарагдаж байна.

Өөрөөр хэлбэл зохиогчоос тухайн газрын тухай өргөн мэдлэг мэдээлэл, ажигч гярхай чанар шаарддаг, тусгаж буй зүйл нь цар хүрээтэй, танин мэдэхүйн ач холбогдолтой байх зэрэг аян замын тэмдэглэлийн шалгуурыг хангасан сонирхолтой нийтлэл гэж үзэж болохоор байна.

Тоймч Б.Алтанхуяг аян замын тэмдэглэлээ “Бороо орж байна” хэмээх гарчгаар эхлүүлжээ. Тэмдэглэлийн эхлэл хэсгийг сонирхолтой шийдсэн нь илт. Б.Алтанхуяг зохиомжийн хувьд тэмдэглэлээ жижиг жижиг гарчиг өгч бичсэн байна. Сэдвийн агуулга тухайн гарчигтайгаа нягт уялдаатай байгаа нь ажиглагдлаа.

Эрэлч хайгуулч байх сэтгүүлчийн үүргээ умарталгүй үзэг дэвтрээ үүргэвчдээ хийн “жиндүү хэр нь таатай, жаахан айдастай боловч амттай санагдах тэр л мэдрэмж”-дээ хөтлөгдөн эх орныхоо умард хязгаарыг бороотой өдөр зорин гарсан тухай энд гарч байна. Удаах гарчгаа “Зорих газрын эхэнд” хэмээн нэрлэжээ. Зохиогч энэ тэмдэглэлээ явсан замын дагуу, тухайн өдрийнхөө үйл явдлыг тэмдэглэн, өөрийн харсан ажигласан зүйл, уулзсан нутгийн хүний яриаг тэмдэглэн өөрт байгаа мэдлэг мэдээллийг баримтаар баяжуулан бичсэн байна. Хөвсгөл аймгийн Мөрөн сумыг зорин хөдлөхдөө бүх юм жинхэнээсээ эндээс эхэлнэ дээ” ...хэмээн (Алтанхуяг.Б, 2021) өгүүлжээ. Сэтгүүлчийн ажигч гярхай байдал уг тэмдэглэлийг уншиж байхад илүүтэй харагдана. Тухайлбал Өгийнуурын эрэг дагуу хоноод явах зуур тэр бээр өглөөний өнгө төрх, өчигдрийн замын турш дахь байгалийн үзэгдэл энд огт өөр байгааг, нуурын дэргэд амрахаар ирсэн зочдыг зугаацуулан нуур дотор хөвөн сэлүүрдэх завийг хараад төрж буй сэтгэгдлээ илэрхийлсэн байдал

зэргээс уншигчийг ямар нэгэн байдлаар хөтлөн, тэмдэглэлийг үргэлжлүүлэн уншихад хүргэж байна. Гурав дахь гарчиг “Умардын нууранд хүрэх зам”-д Цагааннуур сумыг зорихдоо тааралдсан хүн ардын зан араншин байр байдлыг ажиглан тэмдэглэлдээ өгүүлжээ. Зохиогч сууж явсан машины жолоочийн яриагаар үйл явдлыг өрнүүлэн цааш сонирхол татахуйц бичсэн байна. “Хүрэх газрын эхэнд” тэмдэглэлд анх үүргэвчээ үүрээд гэрээсээ ганцаар зориглон гарсан хэдий ч олон хүмүүстэй нөхөрлөн аяллын туршид морь унан Жүгнэгийн давааг уруудан, Тайгын хөндийг өгсөж 30 гаруй км явсны эцэст “отгын газар” ирж буудалласан тухай “уулын бяцхан голууд урсах тул шөнөжин голын харгиа дэрлэн нойрсон тухай, морьд ногоо шир ширхийн зулгааж, хажуугийн модонд үл мэдэх шувуу гуагчих нь сонсогдоно” хэмээн орчин тойрныхоо байдлыг зураглан дүрсэлж энд өгүүлжээ. Зүүн тайгад амьдарч буй цаатан иргэдийн аж амьдралыг жаргал зовлонтой нь, баяр бахархалтай нь сүлэлдүүлэн нутгийн бүсгүй Г.Далайбаяраар төлөөлүүлэн, түүний яриагаар нээн илрүүлсэн нь сонирхолтой байлаа.

Тэднийх 23 отог бүхий айлын нэг. Тэд амар хялбар аж төрдөггүй нь хэн бүхэнд ойлгомжтой ч Далайбаяр эгчийн нүүрэнд байнга инээмсэглэл тодорно. Өөрийн өссөн ахуй соёл, дагшин байгаль цаг уурын хатуу ширүүнтэй цаг үргэлж нүүр тулсан аж төрөхүй, цаатан амьдралдаа хайртай гэдэг нь нүүрний баяслаас нь харагдана. Олон жил ханилсан хань нь эмнэлгийн тусламж авч чадаагүйгээс болж цус харвалтаар нас барж, дөрвөн охинтойгоо үлджээ. Хэцүү бэрх замаар тусгаарлагдсанаас болж эмнэлгийн түргэн тусламж авч чаддаггүй аж.

Цаашлаад “Урц доторх хууч”, “Өглөөний үйл”, “Маргадтай хамт алхсан нь”, “Юм бүхэн гунигтай”, “Учрал бүхэн гэгээн” гэсэн гарчигтайгаар Зүүн тайгын хамгийн өндөр настан Д.Гомбо гуайн хууч яриаг тэмдэглэн, Г.Далайбаярын өглөөг хэрхэн үдэж эхлүүлдэг тухай, тайгад түлш бэлтгэх ажил хамгийн чухлыг онцолж, өвлийн хүйтнийг дулаан зуухны захад өнгөрүүлдэг ч, өвлийн цагт урцны хаяанд жавар тачигнаж өнждөг тул эндхийн хүмүүс урд талаас нь дулаан илч төөнөж, нуруунаас нь хүйтэн жавар хайрсан гэрт өвлийн урт саруудыг туулж давдаг тэвчээртэй хаттай байхад суралцсан хүмүүс гэдгийг тэмдэглээд, “...буцах зам хэзээд гунигтай ч нэхэн санахад учрал бүхэн гэгээн билээ” хэмээн аян замын тэмдэглэлээ төгсгөжээ.

“Монгол хэлний товч тайлбар толь”-д тэмдэглэл гэдгийг “Аливаа хэрэг явдлыг тэмдэглэн бичсэн дэвтэр” гэсэн (Цэвэл.Я, 1963) нь бий. Тэмдэглэл нь баримт, үйл явдлыг бичих аргын хувьд тусгах зүйлийн хэмжээ, дүрслэн үзүүлэх арга, цаг хугацааны өргөн боломжоороо сурвалжилгаас ялгаатай бол, уран сайхны дүр бүтээх зорилт тавьдаггүйгээрээ найрууллаас ялгардаг. Зохиогч аялах замдаа өөрийн зорилгыг биелүүлэхийн тулд очих газрынхаа талаар мэдээлэл цуглуулан, өргөн дэлгэр мэдээлэлтэй аялалд гарсан нь Чи Зи Жианы “Цасан хөшиг”, Сас Каригийн “Миний зүрхэн дэх цаатнууд” зэрэг үүргэвчин дэхь номоос нь мэдрэгдэнэ. Зохиогч сэтгүүл зүйн бичлэгийн хамгийн сонирхолтой, өргөн дэлгэр мэдээлэл багтааж болох нийтлэл-уран сайхны бичлэгийн нэг аян замын тэмдэглэлийг сонгон, түүнийгээ сонирхолтой уран нийтлэл болгож чаджээ.

МОНЦАМЭ агентлагт орчуулагч-редактор, гадаад мэдээний редакцын хариуцлагатай редактор, олон улсын тоймчоор ажиллаж байсан Цэрэнбалжирын Даваажавын “Уулын Карабах”, олон улсын тоймч Б.Адъяахүүгийн “Азербайжан vs Арме-ни: Ужгирсан хямрал дайнд хүргэсэн нь” гарчигтай улс төрийн хоёр тоймд задлан шинжлэл хийв. “Монгол хэлний их тайлбар толь”-д улс төрийн тоймч гэдгийг гадаад, дотоодын улс төрийн амьдралд болж буй үйл явдлыг тоймлон, үнэлж цэгнэж олон түмэнд хүргэх сэтгүүлч хэмээн тайлбарласан байна. (Монгол хэлний их тайлбар толь., 2015)

Армен, Азербайжаны харилцаа хурцадмал байдалд орсон шалтгаан, түүний үр дагаврын талаар тоймч Ц.Даваажав энэхүү нийтлэлдээ тусгажээ. 1991 оны есдүгээр сард “тусгаар тогтносон” уулын Карабах улсыг тунхагласан хэдий ч, Карабахын аюулгүй байдлын талаар олон улсын баталгаа гаргуулах нь асуудлыг зохицуулах зайлшгүй нөхцөл гэж үзэж байгаа хэдий ч Бакугийн байр суурь өөрчлөгдөөгүй бөгөөд Азербай-жаны нутаг дэвсгэрийн зарим хэсгийг /20 хувийг/ армен карабахын тал булаан эзэлсэн явдал асуудлыг зохицуулахад гол саад болж байна хэмээн тоймч дүгнэжээ. Олон улсын тоймч Ц.Даваажав газар нутгийн маргаанаас болж, энгийн иргэд нутгаасаа дүрвэж байгаа тухай болон “Уулын Карабах”-ын аюулгүй байдлыг хангахаар олон улсын бүрэлдэхүүнтэй зуучлагч байгууллага энэхүү хурцадмал байдлыг зохицуулах хэлэлцээ эхлүүлсэн ч байдал өөрчлөгдөхгүй байгаа талаарх үйл явдлыг тоймлон, үнэлж цэгнэж олон түмэнд хүргэж, 2000 онд энэхүү олон улсын тоймыг бичсэн байна.

Мэдээллийн ууган байгууллага МОНЦАМЭ агентлагийн уран бүтээлчдийн Монголын сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлд оруулсан томоохон хувь нэмэр бол дотоод, гадаадын улс төр, эдийн засгийн асуудлыг хөндсөн нь “Тойм” гэж болно. Учир нь ууган хэвлэл мэдээллийн байгууллага МОНЦАМЭ-ийн орчуулагч, редакторууд нь “тойм” хэмээх бичлэгийн зүйлээр дагнан бичиж байсан олон арван улс төр, эдийн засгийн тоймчдыг нэрлэх боломжтой. “Тойм” хэмээх бичлэгийг хөгжүүлэн, төлөвшүүлэхэд мэдээллийн энэхүү агентлагийн сэтгүүлч сурвалжлагчид тоймчдын бүтээлээс харах боломжтой.

Олон улсын тоймч Ц.Даваажавын 2000 онд бичсэн “Уулын Карабах” хэмээх гарчигтай Армен, Азербайжаны улс төрийн нөхцөл байдал өнөөдрийг хүртэл нэг талдаа гараагүй үргэлжилсээр байгааг, олон улсын тоймч Б.Адъяахүүгийн “Азербайжан vs Арме-ни: Ужгирсан хямрал дайнд хүргэсэн нь” гарчигтай 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр montsame.mn сайтад бичсэн улс төрийн тойм давхар гэрчилж байна. Тоймч Б.Адъяахүү энэхүү улс төрийн тоймыг “Нисэх хүчин оролцоогүй дайн”, “Түүх сөхвөл”, “Олон улсын хандлага”, “Холбоотнууд Арменид туслах уу?” гэсэн дөрвөн жижиг гарчгийн дор бичжээ.

Сэтгүүл зүй судлаач, доктор, профессор Л.Норовсүрэн олон баримтын цогц бол “Тойм” бичих сэдэв, харин баримт бол “Тойм” хэмээх бичлэгийн агуулгын гол зүйл мөн гэсэн (Норовсүрэн.Л, Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл, 2008) бол цаг хугацааны өргөн хүрээнд сонгож авсан баримтуудад дүн шинжилгээ хийх замаар хүлээн авагчдад үнэн байдлыг дэлгэн харуулах, богино хугацаанд харьцангуй бүрэн төгс мэдээлэл өгөх арга хэмээн

сэтгүүл зүй судлаач, доктор, профессор М.Зулькафиль тодорхойлсон байдаг. (Зулькафиль.М, 2013).


Тоймч Б.Адъяахүү “Түүх сөхвөл” гарчигт 2000 онд тоймч Ц.Даваажавын бичиж нийтэлж байсан дээрх хоёр улсын түүхээс дурдсан байна. Армени-Азербайжаны хооронд дайн дэгдсэн шалтгаан, дайн дууссан хэдий ч зэвсэгт тулгаралтууд байнга болсоор ирсний учрыг тайлбарлахын тулд өнгөрсөн түүхээс товчхон сөхлөө гээд 20 жилийн өмнөх хоёр улсын хоорондох асуудал Карабахын хямралын талаарх нөхцөл байдлаас дурджээ. Тоймч ганцхан баримт биш, хэд хэдэн баримтад харьцуулалт хийх байдлаар тухайн асуудлыг чухал болохыг баримтаар нээн харуулж чадсан байна.

Тоймч Ц.Даваажав, Б.Адъяахүү нар тойм бичих үндсэн түүхий эд болох “баримт”-ын баялаг нөөц бэлтгэж, шаардлагатай үед нь тойм бичихдээ баримтаараа ашиглаж чадсан нь энэ хоёр тоймчийн бичвэрт ажиглалт шинжилгээ хийх явцад тодорхой

харагдлаа. Эдгээр тоймчид хүн төрөлхтний анхаарлын төвд орсон “Уулын Карабах-ыг тойрсон Азербайжан, Армений харилцаа, хурцадмал байдлыг ажиглан судалж, асуудлын үүсэл хандлага, шинж чанарыг олон баримтыг ашиглан, жишин харьцуулж бодит байдалд хариулт өгчээ.

“Тойм” хэмээх бичлэгийн үндсэн шинж бол дотоод, гадаадад болж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд дэлхий нийтийн анхаарлыг татсан чухал асуудлын талаарх баримтуудыг нэгтгэн судалж, цогц баримт болгон тухайн асуудалд үнэлэлт өгч, дүн шинжилгээ хийдэг тул шинжлэлт бичлэгийн төрөлд багтааж үзэх нь зүйтэй.

Монголын “Шилдэг нийтлэл-99” ботийн 22 дахь дугаар “Монгол Улсын дуу хоолой” ботид орсон МОНЦАМЭ агентлагийн үе үеийн 150 уран бүтээлч ямар редакцад харьяалагдаж байсан болон эзэмшсэн мэргэжлийн задаргааг дараах байдлаар үзүүлээ. Үүнд:



“Монгол Улсын дуу хоолой” номд орсон уран бүтээлчдийн 85 сэтгүүлч, 37 орчуулагч, тоймч 9, инженер 5, бусад

албан тушаалтан 14 байгаа бол 150 уран бүтээлч дотроос МУСГЗ-19, доктор, профессор-13 байна.



МОНЦАМЭ агентлагийн ахмад, дунд, залуу үеийн 150 уран бүтээлчийн 57 хувь буюу (86 хүн) нь дотоодод мэдээлэх нэгдсэн редакцад, 27 хувь буюу (40 хүн) нь гадаадад мэдээлэх

нэгдсэн редакцад, 16 хувь буюу (24 хүн) нь МОНЦАМЭ-ийн удирдлагын түвшинд ажиллаж байсан болон ажиллаж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.



Тус номд орсон уран бүтээлчдийн 67 хувь нь дотоодын их, дээд сургуулийг төгссөн бол 33 хувь нь гадаадын их, дээд сургуульд суралцсан болон мэргэжил дээшлүүлсэн байна.

Дүгнэлт: Үндэсний Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг нь Монгол Улсад өрнөж буй нийгэм, улс төр, эдийн засгийн түүхэн чухал үйл явдлыг хамгийн бодитой эх сурвалжаас хүлээн авч, олон түмэнд төдийгүй гадаад улс оронд шуурхай мэдээлдэг үндсэн үүргийг гүйцэтгэсээр өнөөдөртэй золгожээ. Мэдээг олон нийтэд хүргэхдээ

мэдээний үндсэн шаардлага болох уруугаа харсан пирамидын зарчмыг баримталж ирсэн байна.

МОНЦАМЭ агентлагийн үе үеийн уран бүтээлчид Монголын сэтгүүл зүйн төрөл, зүйлийг баяжуулахад, ялангуяа “Мэдээ” хэмээх бичлэгийн зүйлийг мэргэжлийн түвшинд төлөвшүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

МОНЦАМЭ агентлагийн уран бүтээлчид нийгэмд өрнөж буй үйл явдлын мэдээ, мэдээллийг хамгийн шуурхай боловсруулан бэлтгэж, үнэн бодитой эх сурвалжаас олон нийтэд

дамжуулах үндсэн үүрэгтэй ч “Монгол Улсын Дуу хоолой” номд орсон сэтгүүлч, сурвалжлагчдын нийтлэлд задлан шинжлэл хийж, нэгтгэн дүгнэхэд Монголын сэтгүүл зүйн бичлэгийн бүх төрлөөр бичиж, туурвиж байсан нь харагдлаа.

Эндээс харахад үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагт ажиллаж байсан ахмад, дунд, залуу үеийн уран бүтээлч нийтлэлчид Монголд сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийг баяжуулж хөгжүүлэхэд өөрсдийн тодорхой хувь нэмэр оруулсан гэж үзэх бүрэн үндэстэй байна. Энэ нь Монголын шилдэг нийтлэл цуврал 99 ботийн 22 дахь дугаар “Монгол Улсын дуу хоолой” түүвэрт орсон сэтгүүлч сурвалжлагчдын бичлэгийн арга хэлбэр, нийтлэлийн төрөл зүйлээр батлагдаж байна.

Эшлэл

1. Монголын шилдэг нийтлэл-99.2021.Тэр шөнө халхын уудам нутаг маань доргих шиг болж билээ.Монголын шилдэг нийтлэл-22. боть II. х.8.
2. Монголын шилдэг нийтлэл-99.2021.Тэр шөнө халхын уудам нутаг маань доргих шиг болж билээ.Монголын шилдэг нийтлэл-22. боть II. х.10.
3. Монголын шилдэг нийтлэл-99. 2021. Иргэншсэн хотоос умардын нүүдэлчид хүртэл. Монголын шилдэг нийтлэл-22. боть II. х.50.
4. Цэвэл Я. 1963. Монгол хэлний товч тайлбар толь. х.575.
5. Норовсүрэн. Л. 2019. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. Сэтгүүл зүй-XXI боть. х.105.
6. Зулькафиль.М. 2013. Сэтгүүл зүйн тайлбар толь. х.216.
2. Цэвэл.Я. 1963. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
3. Зулькафиль.М. 2013. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
4. Норовсүрэн.Л. 2019. Сэтгүүл зүй-XXI боть. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. XI дэх боть. УБ.
5. Сандагсүрэн.Д. 2021.Монголын шилдэг нийтлэл-83 боть. УБ.
6. ред. Т.Баасансүрэн. 2001. Миний нэр, миний гэр-МОНЦАМЭ.УБ.
7. ред. Б.Наминчимэд. 2001. Монголд мэдээллийн агентлаг үүсэн хөгжсөн нь. ЭШХ-ын тэмдэглэл. УБ.
8. ред. Б.Наминчимэд. 2001. МОНЦАМЭ агентлаг 80 жилийнхээ ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн нь. ЭШХ-ын тэмдэглэл.УБ.
9. Мөнхбуянт.М. 2006. Хос морьтнууд. УБ.
10. МОНЦАМЭ агентлаг. 2010-2011. Үүсэл хөгжил, түүхэн замнал, ойрын ирээдүйн стратегийн зорилт. ЭШХ-ын илтгэл. УБ.
11. Мэдээллийн агентлагийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлага. 2016. ЭШХ-ын эмхэтгэл. УБ.
12. ред.Ш.Батболд. 2016. МОНЦАМЭ-Дэлхийг Монголд, Монголыг дэлхийд. УБ.

Summary

MONTSAME, national news agency of Mongolia is celebrates its 100th anniversary, fulfilling its obligation to promote Mongolia abroad besides delivering reliable news in the country.

The volume 22 of the 'Best journalism of Mongolia-99' series is dedicated to the news agency on the occasion of its 100th anniversary.

Middle-aged and young journalists who worked in the national media agency MONTSAME played a certain role in developing and enriching the genre of journalistic recording in Mongolia.

The recording method and format of the journalists included in the 22 books of the 99-volume "Voice of Mongolia" series of the best articles in Mongolia is confirmed by the its' genres.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Монголын шилдэг нийтлэл-99. 2021. Монголын шилдэг нийтлэл-22 боть (I, II дэвтэр) УБ.